

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/198/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН БҮЖИНХЭН ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн "ЦЭБЭ Консалтинг аудит" ХХК-ийн
захирал Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Нэхэмжлэл: tuv.audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/25
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
БҮЖИНХЭН ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ГАНПҮРЭВ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын шийдвэрээр сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 15,231.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Тус байгууллагад гэрээгээр түлш халаалт, цэвэр бохир усны нийлүүлэлт хийдэг Төв Чандмань ДЭХГ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор батлагдсан журмын шинэчилсэн тарифыг үндэслэн тооцоо нийлэхэд жилийн эцсийн байдлаар 39,559.1 мянган төгрөгийн өглөгтэй байна. Тус өглөг нь Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 05/1947 дугаар албан бичгийн дагуу үйлчилгээний төлбөр, хураамж нэмэгдсэнээс шалтгаалсан бөгөөд өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Хуучин мөрдөж байсан үнэ

G/Архив/Албан бичиг 2026.02.25

4126020506

тарифаар тооцоо хийж баталгаажуулан санхүүгийн тайланд тусгахыг мэдэгдсэний дагуу авлагын дансанд 8,607.4 мянган төгрөгийн түлш халаалтын авлага шинээр үүсгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1	415,018,325.66	221,332,092.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		258,004,697.78	40,180,194.57
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		258,004,697.78	40,180,194.57
31210	Төгрөг		258,004,697.78	40,180,194.57
31211	Төрийн сангийн харилцах		258,004,697.78	40,180,194.57
33	АВЛАГА		-	8,607,346.58
33500	Бусад авлага		-	8,607,346.58
33510	Байгууллагаас авах авлага		-	8,607,346.58
35	БАРАА МАТЕРИАЛ	6	157,013,627.88	172,544,551.68
35100	Түүхий эд материал		14,500.00	71,550.00
35130	Эм боох материал		14,500.00	71,550.00
35400	Хангамжийн материал		156,999,127.88	172,473,001.68
35410	Бичиг хэргийн материал		-	82,500.00
35420	Аж ахуйн материал		12,359,432.20	9,783,300.00
35450	Барилгын засварын материал		-	13,200.00
35460	Хүнсний материал		1,874,760.00	397,180.00
35470	Бусад хангамжийн материал		142,764,935.68	162,196,821.68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,484,322,222.03	1,503,772,139.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,484,322,222.03	1,503,772,139.44
39200	Биет хөрөнгө		1,279,366,522.10	1,299,139,504.33
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,427,596,681.09	1,491,682,199.09
39202	Хуримтлагдсан элэгдэл		(261,662,773.28)	(323,560,552.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		118,562,211.99	120,468,951.99
39206	Хуримтлагдсан элэгдэл		(44,832,966.70)	(52,559,438.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		91,854,550.74	103,264,538.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(52,151,181.74)	(40,156,193.85)
39300	Биет бус хөрөнгө		204,955,699.93	204,632,635.11
39301	Программ хангамж		880,800.00	880,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(400,100.07)	(573,164.89)
39303	Бусад биет бус хөрөнгө		204,475,000.00	204,325,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		1,899,340,547.69	1,725,104,232.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,899,340,547.69	1,725,104,232.27

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо		1,899,340,547.69	1,725,104,232.27
51100	Засгийн газрын оруулсан капитал		529,803,122.18	529,803,122.18
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		529,803,122.18	529,803,122.18
51200	Хуримтлагдсан үр дүн		545,102,828.51	370,866,513.09
51210	Өмнөх үеийн үр дүн		199,017,229.25	545,102,828.51
51220	Тайлант үеийн үр дүн		346,085,599.26	(174,236,315.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		824,434,597.00	824,434,597.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		1,899,340,547.69	1,725,104,232.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	1,837,994,862.00	1,510,787,313.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		269,621,162.00	1,510,787,313.00
120	Нийтлэг татварын бус орлого		269,621,162.00	152,071,513.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – үндсэн хөрөнгө		203,491,222.00	110,667,213.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – бараа материал		66,129,940.00	41,404,300.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого		-	1,358,715,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	1,358,715,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,568,373,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,373,002,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,373,002,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		195,371,700.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		195,371,700.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,491,909,262.74	1,684,873,628.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,491,909,262.74	1,684,873,628.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,491,726,628.14	1,684,873,628.42

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		912,949,900.05	1,074,683,580.31
210101	Үндсэн цалин		624,291,855.58	743,818,360.06
210102	Нэмэгдэл		281,653,464.47	312,464,639.94
210104	Урамшуулал		7,004,580.00	18,400,580.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		112,115,510.91	131,941,542.90
210201	Тэтгэврийн даатгал		77,360,934.21	88,960,454.90
210202	Тэтгэмжийн даатгал		9,083,890.17	10,745,272.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,592,338.74	5,372,636.00
210204	Ажилгүйдлийн даатгал		4,152,137.22	5,372,636.00
210205	Эрүүл мэндийн даатгал		16,926,210.57	21,490,544.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		187,939,143.40	186,090,753.42
210301	Гэрэл, цахилгаан		16,159,365.42	17,998,095.50
210302	Түлш, халаалт		152,680,037.98	152,669,777.92
210303	Цэвэр, бохир ус		19,099,740.00	15,422,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал		17,622,846.00	14,336,100.00
210401	Бичиг хэрэг		11,048,950.00	14,336,100.00
210408	Бараа материал акталсны зардал		6,573,896.00	-
2105	Нормативт зардал		142,545,952.03	143,668,292.20
210502	Хоол, хүнс		133,199,642.00	125,184,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		9,346,310.03	18,484,232.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,249,922.00	6,000,000.00
210604	Урсгал засвар		7,249,922.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,992,400.00	3,515,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,992,400.00	3,515,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		109,310,953.75	124,637,459.59
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал		19,628,053.85	27,087,184.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,225,150.00	3,323,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		85,457,749.90	94,226,775.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		182,634.60	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		182,634.60	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		182,634.60	-

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4	346,085,599.26	(174,086,315.42)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	150,000.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		-	150,000.00
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (7)=(4)-(5)		-	(150,000.00)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6)=(4)+(5)	6	346,085,599.26	(174,236,315.42)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,568,373,700.00	1,358,715,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,358,715,800.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	-	1,358,715,800.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,358,715,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,568,373,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,373,002,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,373,002,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	195,371,700.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	195,371,700.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,390,572,440.96	1,573,380,823.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,390,572,440.96	1,573,380,823.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,390,389,806.36	1,573,380,823.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	913,056,097.63	1,074,683,580.31
210101	Үндсэн цалин	626,749,029.92	743,818,360.06
210102	Нэмэгдэл	277,390,037.71	312,464,639.94
210104	Урамшуулал	8,917,030.00	18,400,580.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,009,313.33	131,941,542.90
210201	Тэтгэврийн даатгал	75,850,225.91	88,960,454.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,420,740.36	10,745,272.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,760,763.83	5,372,636.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,390,755.08	5,372,636.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,586,828.15	21,490,544.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,939,143.40	194,698,100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,159,365.42	17,998,095.50
210302	Түлш, халаалт	152,680,037.98	161,277,124.50
210303	Цэвэр, бохир ус	19,099,740.00	15,422,880.00
2105	Нормативт зардал	129,862,080.00	123,618,980.00

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210502	Хоол, хүнс	129,862,080.00	123,618,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,249,922.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	7,249,922.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,287,400.00	3,665,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,287,400.00	3,665,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,985,850.00	38,772,720.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,769,200.00	28,065,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,216,650.00	10,707,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,634.60	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	182,634.60	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	182,634.60	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	177,801,259.04	(214,665,023.21)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)	8,268,445.00	3,159,480.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,268,445.00	3,159,480.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,268,445.00	3,159,480.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,268,445.00	3,159,480.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,268,445.00)	(3,159,480.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	169,532,814.04	(217,824,503.21)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	88,471,883.74	258,004,697.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	258,004,697.78	40,180,194.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	824,434,597.00	199,017,229.25	1,553,254,948.43
Тайлант үеийн үр дүн	-	-	346,085,599.26	346,085,599.26
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	824,434,597.00	545,102,828.51	1,899,340,547.69
Тайлант үеийн үр дүн	-	-	(174,236,315.42)	(174,236,315.42)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	529,803,122.18	824,434,597.00	370,866,513.09	1,725,104,232.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,169,710,700.00	1,158,017,700.00	(11,693,000.00)	99.0
12	Татварын бус орлого	1,169,710,700.00	1,158,017,700.00	(11,693,000.00)	99.0
122	Тусламж, санхүүжилтийн орлого	1,169,710,700.00	1,158,017,700.00	(11,693,000.00)	99.0
122005	Төсвөөс санхүүжих	1,169,710,700.00	1,158,017,700.00	(11,693,000.00)	99.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,410,350,100.00	1,375,842,203.21	(34,507,896.79)	97.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,410,350,100.00	1,375,842,203.21	(34,507,896.79)	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,410,350,100.00	1,375,842,203.21	(34,507,896.79)	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,074,686,100.00	1,074,683,580.31	(2,519.69)	100.0
210101	Үндсэн цалин	720,977,600.00	743,818,360.06	22,840,760.06	103.2
210102	Нэмэгдэл	335,305,400.00	312,464,639.94	(22,840,760.06)	93.2
210104	Урамшуулал	18,403,100.00	18,400,580.31	(2,519.69)	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,632,700.00	131,941,542.90	(1,691,157.10)	98.7
210201	Тэтгэврийн даатгал	90,645,400.00	88,960,454.90	(1,684,945.10)	98.1
210202	Тэтгэмжийн даатгал	10,746,800.00	10,745,272.00	(1,528.00)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,373,400.00	5,372,636.00	(764.00)	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,373,400.00	5,372,636.00	(764.00)	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,493,700.00	21,490,544.00	(3,156.00)	100.0
2105	Нормативт зардал	152,113,400.00	123,618,980.00	(28,494,420.00)	81.3
210502	Хоол, хүнс	152,113,400.00	123,618,980.00	(28,494,420.00)	81.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,072,700.00	3,665,900.00	(3,406,800.00)	51.8
210806	Мэдээллийн технологийн зардал	7,072,700.00	3,665,900.00	(3,406,800.00)	51.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,845,200.00	41,932,200.00	(913,000.00)	97.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,778,600.00	28,865,600.00	(913,000.00)	96.9
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	13,066,600.00	13,066,600.00	-	100.0

Төв аймгийн Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(240,639,400.00)	(217,824,503.21)	22,814,896.79	90.5
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	240,639,400.00	217,824,503.21	(22,814,896.79)	90.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	258,004,697.78	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	40,180,194.57	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
12	Татварын бус орлого	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
122	Тусламж, санхүүжилтийн орлого	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,698,100.00	200,698,100.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,698,100.00	194,698,100.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	22,196,300.00	17,998,095.50	(4,198,204.50)	81.1
210302	Түлш, халаалт	152,669,800.00	161,277,124.50	8,607,324.50	105.6
210303	Цэвэр, бохир ус	19,832,000.00	15,422,880.00	(4,409,120.00)	77.8
2106	Эд хогшил худалдан авах	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ3.1 Аудитаар нийт 214,396.9 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл***/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй эзэмшлийн 2 газрын хэмжээг бууруулан бүртгэхдээ, дансны нийт үнээр Үндсэн хөрөнгө худалдсаны гарз дансанд бичиж, буцааж орлого авсан байна.	1	204,475.0			1	204,475.0	1	204,475.0				
Тооллогын үр дүнд Цэцэрлэгийн эрхлэгчийн А/17, А/41 дүгээр тушаалуудаар ашиглах боломжгүй болсон 9,921.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг данснаас хасахдаа бараа материал акталсны зардал дансанд зарлагдсан байна.	1	9,921.9			1	9,921.9	1	9,921.9				
Дүн	2	214,396.9			2	214,396.9	2	214,396.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

3.2 Аудитаар 56.5 мянган төгрөгийн 1 зөрчилд² төлбөрийн акт тогтоосон.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар ажил олгогчоос төлөх нөхөн шимтгэлд 113.0 мянган төгрөг, алдангид 56.5 мянган төгрөг, нийт 169.5 мянган төгрөгийг Нийгмийн даатгалын газарт 2025 оны 06 сарын 27-ны өдөр байгууллагын төсвөөс төлсөн байна.	1	56.5	1	56.5									
Дүн	1	56.5	1	56.5									

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn